



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ*

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**НЭГДСЭН ХУРАЛДААН**



**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр, Пүрэв гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:*

2-3

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:*

4-15

---

1.Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой, “Монгол бахархлын өдөр”-г зориулсан хүндэтгэлийн хуралдааны 4-15 дэлгэрэнгүй тэмдэглэл

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр  
/Пүрэв гараг/-ийн Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой,  
“Монгол бахархлын өдөр”-т зориулсан хүндэтгэлийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хүндэтгэлийн хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 44 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Д.Ганбат, Н.Ганибал, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр;  
Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ж.Ганбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Амарсайхан, Д.Өнөрболор.

“Их хуралдай” танхим дахь Төрийн далбааны дэргэд хүндэт харуул зогсож, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нар суудлаа эзэлсэн байлаа.

Танхимын баруун урд болон зүүн урд дэлгэц дээр “Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой, “Монгол бахархлын өдөр”-т зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан, 2022.11.24” гэсэн үгийг уйгуржин Монгол бичиг, англи хэл дээр бичсэн байв.

“Их хуралдай” танхимын зүүн талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Монгол Улсын анхны Ерөнхийлөгч асан П.Очирбат, Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр, Ц.Элбэгдорж, “Чингис хаан” одонт төр, нийгмийн зүтгэлтэн Р.Гончигдорж, Улсын Их Хурлын гишүүн асан Д.Дэмбэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Содном, нэрт эрдэмтэн, физикч Х.Намсрай, Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч, яруу найрагч Г.Мэнд-Ооёо, Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, “Чингис хаан” одонгоор шагнагдсан Шинжлэх Ухааны гавьяат ажилтан, Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич Д.Доржготов, Америкийн Нэгдсэн Улсын иргэн Жак Уэтерфорд, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга С.Зоригт, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, зөвлөх О.Номинчимэг, С.Энхцэцэг, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга С.Батбаатар, Дотоод аудитын албаны дарга бөгөөд дотоод аудитор Я.Баттогтох, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, Цахим парламент, инновацын газрын дарга Б.Өлзийбат, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга С.Алтанхуяг, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Жамбалдорж, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Эрдэнэбаяр, Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа, Парламентын сурталчилгаа, мэдээллийн төвийн дарга Л.Нинжжамц, Парламентын номын сангийн дарга С.Янжинхорлоо нар,

Танхимын баруун талд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дарга Н.Чинбат, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын сайд Ч.Номин, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Мягмарцэрэн, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нар,

Мөн Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар, Нэгдсэн үндэстний байгууллага /НҮБ/, түүний төрөлжсөн болон олон улсын байгууллагын Монгол Улс дахь суурин төлөөлөгчид, зочид урилгаар оролцов./нэрсийг хавсаргав/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой, “Монгол бахархлын өдөр”-т зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан нээснийг мэдэгдэв.

Танхимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэж, Улсын Их Хурлын дарга болон хуралдаанд оролцогсад босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хүндэтгэлийн хуралдаан хаасныг мэдэгдэв.

Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн Олон нийттэй харилцах албаны ахлах референт Г.Хэрлэн, Гадаад харилцааны хэлтсийн референт О.Гэрэлхүү нар хариуцан ажиллав.

Хуралдаан 40 минут үргэлжилж, 76 гишүүнээс 49 гишүүн хүрэлцэн ирж, 64.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 40 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2022 оны 11 дүгээр сарын 24-ний  
өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
12 цаг 00 минут.

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Та бүхний энэ  
өглөөний амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд  
ээ, хүндэт зочид оо та бүхний энэ  
өдрийн амар амгаланг айлтган  
мэндчилье.

Их эзэн Чингис хааны  
мэндэлсний 860 жилийн ой, “Монгол  
бахархлын өдөр”-т зориулсан Улсын  
Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан  
Төрийн ордны “Их хуралдай” танхимд  
зохион байгуулагдаж байна.

Хүндэтгэлийн хуралдаанд  
Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн  
Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд  
Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Үндсэн  
хуулийн цэцийн дарга, Улсын дээд  
шүүхийн ерөнхий шүүгч, Засгийн  
газрын гишүүд, Улсын ерөнхий  
прокурор зэрэг төрийн өндөр албан  
тушаалтнууд, Улсын Их Хуралд  
ажлаа шууд хариуцан тайлагнадаг  
байгууллагуудын болон Нийслэлийн  
удирдлагууд, Монгол Улсын төрийн  
дээд шагнал Тэргүүн зэргийн одон  
“Чингис хаан” одонт шагналтнууд,  
Монгол Улсын үе үеийн Ерөнхийлөгч  
нар, мөн Монгол Улсад суугаа  
Дипломат төлөөлөгчийн газрын  
тэргүүн нар, НҮБ түүний төрөлжсөн  
болон олон улсын байгууллагын Монгол  
Улс дахь суурин төлөөлөгчид уригдаж  
оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын  
Хүндэтгэлийн хуралдаан нээснийг  
мэдэгдье.

Эрхэм хүндэт Монгол Улсын  
Ерөнхийлөгч өө,

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий  
сайд аа,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүндэт зочид, хатагтай, ноёд оо,

Билгийн тооллын Өвлийн  
тэргүүн сарын Шинийн 1-нийг  
Монголын төр, ард түмэн Эзэн богд  
Чингис хааны мэндэлсэн өдөр,  
“Монгол бахархлын өдөр” болгон  
тэмдэглэдэг сайхан уламжлалтай.  
Энэ жилийн хувьд Эзэн хааны маань  
түмэн өлзий гийсний 860 жилийн ой  
давхцан тохиож байна.

Энэ түүхэн үйл явдлыг  
тохиолдуулан Монгол Улсын Их Хурал  
Хүндэтгэлийн хуралдаанаа зарлан  
хуралдуулж байна.

“Монгол бахархлын өдөр”-ийг  
тохиолдуулан улс орныхоо тусгаар  
тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний  
эв нэгдлийг бататган бэхжүүлэх,  
төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг  
судалж, хойч үедээ өвлүүлэх,  
тэдгээрийг дэлхий дахинд сурталчлан  
таниулахад үнэтэй хувь нэмэр  
оруулж, төр, нийгэм, үндэстнийхээ  
өмнө онцгой гавьяа байгуулсан  
хүмүүст Монгол Улсын Төрийн дээд  
шагнал Тэргүүн зэргийн одон “Чингис  
хаан” одонг хүртээдэг уламжлалтай.

Энэ жил Их Эзэн Чингис хааны  
мэндэлсний 860 жилийн ой, “Монгол  
бахархлын өдөр”-ийг тохиолдуулан  
Монгол Улсын Шинжлэх ухааны

гавьяат зүтгэлтэн, доктор, профессор, академич Дэчингунгаагийн Доржготов, Америкийн Нэгдсэн Улсын Монголч эрдэмтэн, Макалестер коллежийн Эмерит профессор Жак Уэтерфорд нарт хүртээлээ.

Академич Д.Доржготов, профессор Жак Уэтерфорд болон “Чингис хаан” одонт Хүндэт эрхмүүд, Улсын Их Хурлын эрхэм гишүүд, хүндэт зочид төлөөлөгчид, Монголынхоо нийт ард түмэнд Эзэн Чингис хааны түмэн өлзий гийсний 860 жилийн ой, Монголчуудын Монгол хүн болж төрснөөрөө бахархах, Монгол өв соёл, агуу түүхээрээ бахархах “Монгол бахархлын өдөр”-ийн баярын мэндчилгээ дэвшүүлж, сайн сайхныг ерөөе.

Чингис хаан Монгол туургатныг нэгтгэн Их Монгол Улсыг байгуулж, төр засах арга ухаан, хууль цаазыг тогтоон хэрэгжүүлсэн нь хүн төрөлхтний төрт ёсны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Чухам тийм ч учраас түүнийг дэлхийн түүхийн Мянганы суут хүмүүнээр өргөмжилсөн юм.

Эзэн Богд Чингис хааныхаа суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, үр хойчдоо өвлүүлэн үлдээх нь өнөөгийн бидний хүндэт үүрэг бөгөөд Монголынхоо сэргэн мандлын шинэ ирээдүйг бүтээх, улс үндэстнээрээ, түүх соёлоороо бахархах үзэл хандлагыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

Энэхүү түүхэн ойг угтаж, Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Эзэн хааныхаа агуу үйл хэрэг, үнэт өвийг судлан дэлгэрүүлэх,

дээдлэн мөнхжүүлэх, эв эеийг бататгах зорилгоор Чингис хааны эш хөргийг албан байгууллага, айл өрх бүр хүндэтгэн залах тухай зарлиг гаргасан.

Өнгөрсөн сард дэлхийн жишигт нийцсэн, Ази тивд томоохонд тооцогдох “Чингис хаан” хаад язгууртны музейг бүтээн босгож, ашиглалтад орууллаа. Энэхүү музей Монгол нутагт анхны төрт улс байгуулагдсан Хүннү гүрнээс эхлээд Чингис хаан, түүний угсааны алтан ургийн ноёдын уг сурвалж, үйл хэрэг, Монголчуудын бүтээн бий болгосон соёл түүхийг өргөн дэлгэр нээн харуулж чадсан нь хүн төрөлхтний түүх, Чингис хааны судлалд Монгол түмний оруулж буй үнэ цэнтэй хувь нэмэр гэж үзэж байна.

Хоёр хоногийн өмнө бид Монголчуудын эх түүх, утга соёлын түүхэн дурсгалт бүтээл “Монголын нууц товчоон”-ыг 60 жилийн турш тасралтгүй судалж өөрийнхөө судалгааны бүтээлийг туурвисан эрдэмтэн доктор Балдандоржийн Сумъяабаатарын бүтээн туурвисан “Монголын нууц товчоон: Иж бүрэн судалгаа” хэмээх 2262 хуудастай номыг танилцуулж, нээлт хийх ёслол болсон.

Мөн Чингис хааны өвөг дээдсээс эхлэн Ил хаант улсын Өлзийт хаан хүртэлх бүхий л хаад, хатад, жанжид болон Монголын олон аймаг овог, дэлхийн улс орнуудын түүх, улс төр, эдийн засаг, соёлын бүхий л онцлогийг тод томруунаар бичиглэн үлдээсэн бүтээл болох Рашид ад дин Фазуллахын “Шашидырын чуулган” хэмээх 1162 хуудастай номыг Соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт орчуулагч

*Готовын Акимын орчуулснаар олон нийтэд хүртээл болголоо.*

*Эрхэм гишүүд ээ, Их эзэн Чингис хаан шударга ёс, эв эеийн сэтгэлгээг Монгол төрийн бодлогын ёс суртахууны үндэс, хөдөлшгүй зарчим болгон тунхагласан. Үүнийхээ хүчээр дэлхийн бодлогыг тодорхойлогч Эзэнт гүрнийг байгуулж, улмаар энэ ертөнцөд 140 гаруй жил амар амгаланг тогтоосон билээ.*

*Тэрбээр нэгэнтээ “Хаан миний бие умард зүгийн их хээр талд аж төрөн сууж, чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод, бүрэлгэн сүйтгэхийг хориглон зогсоож, өмсөх хувцас, идэх хоолоо адуучин үхэрчинтэйгээ хуваалцан, ард иргэдийг хүүхэдтэйгээ адил энэрэн үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээ мэт хүндэлж, эе эвийг сахиулж, энэрэл хишгээ түгээж явна” хэмээн айлдсан түүхтэй.*

*Энэ бол шударга ёсыг эрхэмлэдэг, гагцхүү хууль засагладаг, ард түмнээ энэрдэг Төр оршин байхын утга учрыг тодорхойлсон хэрэг бөгөөд Монгол хүн бүр, түүний дотор төрд алба хаагч хэн бүхэн эрхэмлэн санаж явах учиртай сургаал юм.*

*Чингис хааны байгуулж төлөвшүүлсэн төрт ёсны тогтолцоо, зарчим, төрийн ёс бэлгэдлийн үзэл санааг Монгол Улс үе үеийн Үндсэн хуульдаа тусган өнөөг хүртэл өвлөн уламжлан ирсэн түүхтэй.*

*Цаашид Их хааныхаа үйл хэрэг, билиг сургаал, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг судлахын зэрэгцээ өнөөгийн төрийн бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаандаа үзэл санааг нь тусган хэрэгжүүлэх, төрийн*

*алба, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ болгож мөрдүүлэх явдал нэн чухлыг тэмдэглэж хэлэхийг хүсэж байна.*

*Төр төвшин, түмэн олон маань амгалан байж, хөх Монголын суу алдар ямагт мандан бадрах болтугай.*

*Одоо Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Таныг үг хэлэхийг урьж байна. Индэрт урьж байна.*

*У.Хүрэлсүх: Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсын гал голомтыг суугаа Монголчууд аа, Наран ургахаас наран жаргах хүртэлх олон газар оршин суугаа элэг нэгт*

*Монгол ахан дүүс ээ,*

*Манай улсыг удирдаж ирсэн үе үеийн Ерөнхийлөгч, төрийн тэргүүн нар аа,*

*Эрхэм хүндэт УИХ-ын дарга, Ерөнхий сайд аа,*

*Монгол төрийн эрхэм түшээд ээ,*

*Эрхэм нөхөд өө,*

*Эрхэм хүндэт зочид оо,*

*Хүн төрөлхтний түүхэн дэх аугаа удирдагч, өнөөгийн дэлхий ертөнцийг үндэслэгчдийн нэг, Мянганы суут хүмүүн Монгол түмний өнө мөнхийн бахархал, Эзэн Чингис хааны мэндэлсний түүхт 860 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.*

*Монголчууд бид их хувь заяатай ард түмэн. Мөнх тэнгэр Монголчууд бидэнд агуу их суу билигт Хаадын хаан Их эзэн Чингис хааныг заяасан билээ. Одоогоос 800 жилийн тэртээ эзэн Чингис хаан эцэг өвгөдийн шүтээн Бурхан халдун хайрхны өвөрт Мөнхийн рашаант Уст 3 голын сав газарт*

Талын Монгол язгууртан Есүхэйбаатар, ухаан цэцэн хатан Өөлүн эхийн ууган хөвгүүн Тэмүүжин болж мэндэлсэн. Тэмүүжин эв эе эвдрэлцсэн, тарж бутарсан Монгол овогтон аймгуудыг нэгтгэн Их Монгол улсыг байгуулж, Хүннү гүрнээс улбаатай төрт ёсны алтан аргамжийг бататган бэхжүүлж, Монгол төрийн гал голомтыг сэргээн бадрааж, ертөнц дахинд дуурьсагдсан Их эзэн Чингис хаан болон өргөмжлөгдсөн түүхтэй.

Чингис хаан бол Монгол үндэсний тусгаар тогтнол, оршин тогтнохын баталгаа, манай ард түмний үнэт зүйл, оюун санааны их ундарга болсон өнө мөнхийн эзэн хаан юм. Их эзэн Чингис хаан бол өвөг дээдсийнхээ байгуулсан төрт ёсны түүхийг уламжлан төр улс, түмэн олноо засах билэг ухааныг өвлөн, зон олныхоо сэтгэлийг хурааж, итгэлийг тэтгэж, өнгөрснөө санаж, одоогоо мэдэж, ирээдүйгээ таньдаг, ертөнцийн түүхийг бүтээхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан агуу хүн юм.

Их хааны эвийн хүчийг зангидаж, хамаг Монголыг нэгтгэн хууль цаазыг тогтоож, Тэмүүжин хөвгүүнээс Тэнгэрлэг хаан болох хүртэлх хагас жарны түүх их үйл хэрэг тийм ч амар хялбар байгаагүй. Чингис хаан ураг төрөл угсаа нэгтнүүдээ гээгдэж, балчир насаа өнчрөл хагацал үзэн хат сууж бэрхийг бэрх хэмээн няцалгүй, хүндийг хүнд хэмээн цөхрөлгүй, бэрхшээл зовлонг гэтлэн давж, эр зориг, эрдэм билиг, суу заль, сэтгэлийн хүчээрээ нүүдэлчин овог аймгуудыг нэгтгэн Их Монгол Улсыг байгуулсан түүхтэй.

Ийнхүү Чингис хаан Их Монгол Улсыг байгуулсан явдал нь Мөнх тэнгэрийн хүчин дор олон улс үндэстэн эв найрсалтайгаар зэрэгцэн орших, урьд хожид дэлхийн түүхэнд тохиож байгаагүй агуу их үйл хэргийг эхлүүлсэн юм. Түүний цогцлоон байгуулсан Их Монгол Улс дэлхийн түүхийн 2 зууныг Монголчуудын зуун болгон хүн төрөлхтний түүхэнд үлдээж чадсан юм.

Их Монгол Улс эв нэгдлээ бэхжүүлэн, төр улсаа мандуулж, хууль цаазын дор түмэн олныг төвшитгөн захирч, Ази, Европ дахь дайн тулаан, зөрчил мөргөлдөөнийг зогсоож, ертөнц дахинд амар амгаланг тогтоон, сүр хүчээрээ дэлхий дахинд гайхагдсан эзэнт гүрэн болгон өргөжин тэлсэн билээ.

Монголын эзэнт гүрний газар нутгийг зүүн зүгт Номхон далайгаас эхлэн баруун зүгт Персийн булан, Дунай мөрөн хүртэлх 23 сая хавтгай дөрвөлжин километр газар нутаг буюу дэлхийн түүхэнд байгаагүй хамгийн их хуурай газрын эзэнт гүрэн байсныг Британника нэвтэрхий тольд тэмдэглэн үлдээсэн байна. Энэ том газар нутагт оршин байсан өөр өөр хэл соёл, шашин шүтлэгтэй, олон сая ард түмнийг цөөхөн хүн амтай, нүүдлийн соёл, иргэнишилтэй Чингисийн Монголчууд 2 зууны туршид нэгтгэн зангидаж, засаглаж чадсаныг өнөөдөр ч дэлхий дахин сонирхон судалсан хэвээр байна.

Далай эх хааны суу билиг, үүх түүх, үзэл санаа, үйл хэргээс хүн төрөлхтөн, дэлхийн улс орнуудын удирдагч нар судлан суралцаж ирсэн нь Монголчууд бидний өнө мөнхийн бахархал юм. Энэтхэгийн анхны ерөнхий сайд Жавахарлал Неру Чингис



хааныг дэлхийн түүхэн дэх Македоны Александр, Юлий Цезарь нартай эгнэшгүй цэргийн сод ухаантан, удирдагч эргэлзээгүй мөн байсан хэмээгээд цэргийн давуу хүчтэй байлаа ч дайтахыг бус найрамдахыг эрхэмлэдэг нэгэн байсан хэмээн үнэлсэн байдаг.

Үнэхээр түүний байгуулсан эзэнт гүрэн цэргийн эрдэм, дайтах урлаг, сүр хүчээр хосгүй байсан хэдий ч хууль цааз, эв эе, энх амгаланг эрхэмлэн олон улс түмнийг засагласан гайхамшигт түүхтэй юм.

Чингис хаан болон түүний залгамжлагчид өнөөдөр ч хүн төрөлхтний өмнө тулгарч буй улс төр, эдийн засаг, шашин шүтлэг, иргэншил хоорондын дайн дажин, зөрчил мөргөлдөөнийг 8 зууны тэртээ даван туулж, Монголын их амар амгалан цогцлоон байсныг Вашингтон пост сонин 1995 онд Чингис хааныг дэлхийн мянганы суут хүнээр нэрлэснийг та бүхэн бас мэдэж байгаа.

Монголын их амар амгалан тогтсоноор Евро Азийн ард түмэн бүтээн туурвих, барьж байгуулах, судлан шинжлэх үйл хэрэгт илүү анхаарах боломж бүрдэж, тооны ухаан, анагаах ухаан, гүн ухаан, одон орон, түүх, газар зүй, утга зохиол, дуу хөгжим, дүрслэх урлаг, уран барилга зэрэг шинжлэх ухаан, соёл урлаг, танин мэдэхийн олон сар хөгжихийн зэрэгцээ хуурай газрын болон усан замын газрын зургууд хийгдэж, цэрэг дайны болон МАА, газар тариалангийн шинэ дэвшилтэт технологиуд түүхэнд бий болсон юм.

Мөн өргөн уудам газар нутгийг өртөө улбаагаар холбосноор тухайн үеийн зам тээвэр, харилцаа холбоо эрс

эрчимжин хөгжжээ. Чингис хаан болон түүнийг залгамжилсан Монгол хаад, торгоны замыг хөгжүүлэн аюулгүй байдлыг хангаснаар Солонгосын хонхроос газар дундын тэнгис хүртэлх өргөн уудам нутагт худалдаа арилжаа өргөжин тэлж, хөгжиж, цаасан мөнгө гүйлгээнд нэвтэрч, дэлхийн эдийн засгийн хөгжилд онцгой том хувь нэмэр оруулсан байна.

Их Монгол Улс тухайн үед дэлхийн улс төр, эдийн засгийн төв байсан хэмээн судлаачид үздэг. Үүнийг гэрчлэх бас нэгэн түүх соёлын өв бол Хархорин хот юм. 1220 онд Чингис хаан Хархорин хотыг байгуулах Их Монгол Улсын нийслэлийг шилжүүлэх зарлиг буулгажээ. Хархорин хотод олон газрын эрдэмтэн мэргэд, уран бүтээлчид, гар урчууд, худалдаачид, орон орны хаад язгууртны элч төлөөлөгчид аж төрж, морилон саатдаг олон шашин, соёл иргэншлийн төв байсан юм. Монголын эзэнт гүрний ивээл дор ардчилсан үзэл санаа, үнэт зүйл тэнд цэцэглэн хөгжиж байлаа. Евро Азийн улс орнууд, газар нутаг, улс төр, эдийн засаг, нийгэм байгууламжийн хувьд Монгол төрийн засаглал дор нэгдсэнээр улс орон, бүс нутгийн зааглаж байсан соёл иргэншил, үзэл суртлын хана хэрэм нуран унаж, олон ард түмэн харилцан хүндэтгэлтэйгээр зэрэгцэн орчих боломжтойг хүн төрөлхтөнд анх удаа мэдрүүлсэн түүхтэй юм. Тухайн үед Их Монгол Улс хэмжээгүй эрхт хаант засагтай байсан хэдий ч ардчилсан ёсны зарчмыг хөгжүүлж байлаа. Үүний нэг тод жишээ бол Хархорум хотод бурхны, загалмайтны, исламын зэрэг янз бүрийн 12 сүм хийд зэрэгцэн оршиж, үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулж, олон шашны элч төлөөлөгч нар хуран чуулж, мэтгэлцэж байсан

дэлхийн түүхэнд гарсан анхны тохиолдол хэмээн бүртгэгджээ. Энэ бол тухайн цаг үеийн олон ард түмний ертөнцийг үзэх үзэл, итгэл үнэмшил, шашин шүтлэгийн олон янз байдлыг хориглон цаазалж, үнэт зүйлд нь халдалгүйгээр хүндэтгэлтэй хандаж байсан явдал бөгөөд хүн төрөлхтний түүхэнд гайхагдан үлдэж, өнөө цагийн соёлт ертөнцийн тулгуур зарчмуудын нэг болон өвлөгдөн үлдсэн байна.

Миний Монголын ард иргэд ээ, Далай их хаан Евразийн эзэнт гүрнийг үндэслэн байгуулсан дэлхийн хүн байсан тул 13 дугаар зуунаас эхлэн олон улс орон, түүний намтар түүхийг олон хэлээр бичиж хэвлэсэн байна. Тиймээс Чингис хаан бол дан ганц Монголчуудын түүх биш, дэлхий нийтийн түүх гэдгийг олон орны удирдагчид, нэртэй эрдэмтэн судлаачид, шашины тэргүүнүүд хүлээн зөвшөөрсөн байна.

2004 онд Америкийн нэрт эрдэмтэн Жак Уэтерфордын бичсэн “өнөөгийн ертөнцийг үндэслэгч Чингис хаан” хэмээх алдарт бүтээлд “Чингис хаан бол орчин цагийн дэлхий ертөнцийн үзэл санаа, үндэс суурийг тавьсан их хаан” хэмээн онцолжээ. Энэхүү алдарт бүтээл дэлхий нийтийн анхаарлыг татаж, эзэн Чингис хааны агуу түүхийг хүн төрөлхтөнд дахин таниулсан бөгөөд “Нью-Йорк Таймс” сонинны шилдэг бүтээлээр шалгарсан билээ. Мөн Жак Уэтерфорд бичихдээ Чингис хааны мөрдүүлж байсан хуулийг 13 дугаар зууны үед Монголд очиж байсан Карпини, Рубрук нар шагин өгүүлж байсан бөгөөд Монголчууд эзэн Чингис хааны тогтоосон хууль дүрмийг хэрхэн хүндэлж, дагаж мөрддөг байсныг тэд олонтоо бичиж байжээ хэмээн үлдээсэн байна.

Эрхэм хүндэт Чингис хааны Тэргүүн дээд шагнал авсан Жак Уэтерфорд танд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Таныг мөнх тэнгэр тэтгэж байх болтугай.

14 дүгээр зууны үеийн Английн зохиолч Чаусер Чингис хааныг хууль шүүхийн “агуу хаан” хэмээн нэрлэж байв. Түүний бичсэнээр Чингис хаан өргөсөн тангарагтаа өөрөө үнэнч байсан, тэр үеийн хэмжээгүй эрхт хаад өөрийгөө хуулиас дээгүүр тавьдаг байсан бол Чингис хаан энгийн иргэдтэй адил хуульд захирагддаг байсан нь маш онцлог байв хэмээн бичиж үлдээсэн байна.

Мөн Францын эрдэмтэн, дорно дахины агуу судлаач Поль Пеллио Чингис хааны байлдан дагуулалтын үеийг дэлхий ертөнцөд урьд өмнө нь тохиолдож байгаагүй хамгийн агуу гайхамшигт үйл явдал хэмээн бичиж үлдээсэн байна. Түүнчлэн Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойгоор БНСУ-ын Ерөнхийлөгч, Энх тайвны Нобелийн шагналт Ким Дэ Жүн Чингис хааны байгуулсан гавьяа дараах түүхэн ач холбогдолтой юм гээд нэгдүгээрт, Өрнө Дорныг холбосон хуурай болон далайн замыг бий болгосон, хоёрдугаарт, Христосын болон исламын шашин дорно зүгт дэлгэрэхэд чухал нөлөө үзүүлсэн, гуравдугаарт, Газар зүй, одон орон судлал, тооны ухаан, газар зүй, газрын зургийн технологийг өрнөдөд дэлгэрүүлсэн, дөрөвдүгээрт, Өрнө дорнын соёлын болон эдийн засгийн харилцааг эрчимжүүлэхэд дэлхийн ирээдүйн хөгжлийн үйл явцыг өөрчилсөн хэмээн бичиж үлдээсэн байна.

Тэгвэл 14 дүгээр Далай лам хэлэхдээ 1206 онд Монголын тархай

бутархай овог аймгуудыг нэгтгэн Чингис хааныг их хаанд өргөмжилж, Аугаа Их Монголын эзэнт гүрнийг байгуулсан билээ. Тэрээр өөрийн бие болоод сэтгэлийн хичээл зүтгэлээр их амжилтыг олсон юм. Өнөөдөр түүний үлдээсэн гавьяа бахархал нь Монголын тусгаар тогтнол, эв нэгдэл, эрх чөлөө юм, түүний агуу их хичээл зүтгэлийг үлгэр дуурайл болгон хөгжүүлж, зөвхөн эд баялгийн дэвшил бус хүний дотоод үнэт зүйлийг хөгжүүлэхийн төлөө ажиллахыг Та бүхнээс уриалж байна гэж Монголчуудад хандан бичжээ.

Харин Ромын пап 16 дугаар Бенедикт 2006 онд бичихдээ Чингис хаан Монголын ард түмний улс төр, нийгэм, соёлын онцлогийг дэлхий дахинаа таниулахад өөрийн хувь хүний чанараар гайхамшигтай хувь нэмэр оруулсан хүн. 1206 оноос өнөөг хүртэлх хугацаанд хүн төрөлхтний хөгжилд багагүй өөрчлөлт гарсан хэдий ч Их Монгол Улс болон түүний бусад соёл иргэнишлтэй харилцах харилцаанд Чингис хааны оруулсан хувь нэмэр үлэмж ихээр үлдсэн нь гарцаагүй юм. Энэхүү ололт амжилтыг зөвхөн судлаад зогсохгүй өөрсдийн зүй ёсны үндэсний бахархлыг бусад ард түмний соёл иргэнишлтэй харилцах харилцаанд эв зүйтэй хослуулж, үлгэр дуурайл болох нь чухал билээ хэмээн тэмдэглэн бичсэн байна.

Мөн ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин хэлэхдээ Чингис хаан эхийг нь тавьсан Монголын төрт улс дэлхийн түүхийн өрнөлд ихээр нөлөөлсөн гэж хэлсэн бол Япон улсын Ерөнхий сайд Жуничиро Койзуми Евроазийн газар нутгийг эзлэн захирч байсан Монголын эзэнт гүрний үед анх дэлхий хэмээх ерөнхий ойлголт бий

болсноор дэлхийн түүх үүссэн гэж үздэг Японы эрдэмтэн Окадо Хидэхирогийн дүгнэлтийг ишлэн дурдаад мөн авьяас чадалтай, эрдэмтэй гадаадын иргэдийг өндөр албан тушаалд тохоон томилох, нэгдсэн мөнгөн тэмдэгтэй болгох, шашин шүтэх эрх чөлөөг Чингис хааны явуулсан бодлогыг авч үзвэл Монголын эзэнт гүрэн даяарчлалын анхдагч нь байжээ хэмээн тэмдэглэн үлдээсэн байна.

Хүн төрөлхтний түүхээс авч үзсэн ч гэсэн нэгэн агуу түүхийн шинэ эрин үеийг эхлүүлсэн Чингис хааны бодит байдал нь тэр үеийн тухай улам ихийг бидэнд мэдрүүлэх болно гэж хэлсэн байна.

Тэгвэл эртний түүхт Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Ерөнхийлөгч Хосни Мубарак хэрэгтэй энэхүү агуу их удирдагчийн түүхэн үүрэг нь Монгол овог аймгуудыг нэгтгэж, Монгол Улсыг байгуулаад зогсоогүй хүн төрөлхтний түүхийн дунд үед дэлхийн газрын зургийг шинээр зурахад гүнзгий нөлөө үзүүлсэн юм. Үүгээр ч үл барам Чингис хаан улс төрийн агуу сэтгэгч цэргийн гарамгай содон ухаантан, жанжин, удирдан зохион байгуулах өндөр чадвартай хүн байсан нь түүний эрх барих хугацаандаа бий болгосон иргэний болон цэргийн хөгжингүй тогтолцоо, өөрөөс нь хойш олон жил мөрдөгдсөн хууль ёс, дэг журам харуулж ирснийг түүхчид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг билээ гээд Чингис хаан хэдэн жилийн дотор хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн агуу гүрнүүдийн нэг болох Монголын эзэнт гүрнийг байгуулж чадсан юм гэжээ.

Мөн тэр түүний нэр алдар, даян дэлхийд түгж, түүхчид 2 дугаар

*Рамсес, 3-дугаар Тутмоз болон агуу их Александр болон Цезарь нарын хамт дэлхийн удирдагчдын жагсаалтад нэрийг нь оруулсан юм. Түүний эзэнт гүрний хил хязгаар нь Номхон далайгаас Хар тэнгис, Сибириэс Зүүн өмнөд Азийн хойд хил хүртэл үргэлжилж байсан билээ. Египет болон энэ бүс нутагт Чингис хаан болон түүний залгамжлагчдыг гайхамшигт удирдагч гэсэн ойлголт давамгайлдаг хэдий ч Ислам улс үндэстний зарим хэсэгт нь түүнийг Хаваризмын төрийг түлхэн унагаж, Хорезм, Самарканд, Бухарыг булааж, мөн Хорасан, Афганистан, Иран, Ирак болон Эл Маширекийг эзэлж байснаар нь түүнийг булаан эзлэгч гэж дурсдаг хэмээгээд эл бүгдийг үл харгалзан ийм удирдагчийг өнөө үеийн шалгуураар бус харин тухайн үед нь мөрдөгдөж байсан голлох шалгуураар нь хэмжих нь зүйтэй юм. Өөрийнх нь цаг үеийн шалгуураар бол Чингис хаан аугаа их байлдан дагуулагч, удирдагч хэмээн алдаршсан байсан юм. Тэр улс үндэстнээ нэгтгэж, тархай бутархай байсан цөөхөн хэдэн овог аймгуудыг хүчирхэг улс болгон өөрчилж, улмаар өргөн уудам газар нутагтаа их гүрэн болгон тэлэн хөгжүүлсэн юм. Энэхүү эзэнт гүрний газар нутгийг өргөтгөн тэлэх үйл хэргийг түүний тэнгэрт хальсан хойно нь ч үе залгамжлагч нь үргэлжлүүлж, тэдний цэргийн хүчин Дунай мөрнийг гатлан өнөөгийн Германы хилд тулж ирж байсан түүхтэй хэмээн дүгнэн бичсэн байна.*

*Тэгвэл БНТУ-ын Ерөнхийлөгч Рэжэп Эрдагон бичихдээ 1206 онд байгуулагдсан Их Монгол Улс нь дэлхийн түүхэнд гарсан хамгийн том үргэлжилсэн хуурай газрын эзэнт гүрэн байлаа. Энэ нь хүн төрөлхтний түүхийн хөгжлийн явцад нөлөө үзүүлэх нь эргэлзээгүй байсан юм. Чингис хаан түүхэнд хамгийн том*

*эзэнт гүрнийг байгуулсан удирдагч байсан төдийгүй аугаа их төр улсыг захирч чадсан цэргийн том жанжин гэж бичигддэг юм.*

*1206 онд Чингис хаан агуу их эзэнт гүрнийг үүсгэн байгуулж, тусгаар тогтнолын нэр хүндийг олж авсан бөгөөд тэрээр 1227 онд насан өөд болох үед Монголын эзэнт гүрэн Хар далайгаас Номхон далай хүртэлх газар нутгийг эзэмшиж байв. Нөхөр ч бай, дайсан ч бай олон ард түмний түүхэнд өөрийн байлдан дагуулаар дурсагдан үлдсэн аугаа их Чингис хааны зорьсондоо хүрэх чадвар, цэргийн эрдэм нь Монголын Их эзэнт гүрэнд их зүйлийг өгчээ.*

*Өнөөгийн 1,5 сая хавтгай дөрвөлжин километр өргөн уудам нутагтай, эрч хүчтэй, залуу хүн амтай Монгол Улс орчин үеийн дэлхий ертөнцийн идэвхтэй улс төрийн улс орнуудын нэгэн болон хөгжин цэцэглэж байна.*

*Монгол Улс дэлхийн түүхэнд өөрийн өвөрмөц байр суурь болон соёлын өвөө хадгалан үзэж чадсан юм хэмээн бичиж үлдээсэн байна.*

*Мөн АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтон 1206 онд Чингис хаан Их Монгол Улсыг нэгтгэн зангидсан үеэс хойш Монголчууд тусгаар тогтнол, эрх чөлөөг гүнээ эрхэмлэн дээдэлж ирсэн хэмээн цохон тэмдэглэжээ. Тэгвэл Франц улсын Ерөнхийлөгч Жак Ширак Чингис хаан түүний үйл хэргийг тодорхойлохдоо дэлхийг дурсгаж байсан энэхүү их байлдан дагуулагч ямар их өндөр соёлтой, ирээдүйг урьдчилан харагч өөрийн нийгэм цаг үеийг тодорхойлогч байсныг тэр бүр бүрэн дүүрэн судалж, мэдэж амжаагүй байна. Чингис хаан*

овог аймгуудын тогтолцоог задлан халж, үндэсний эв нэгдлийг үүсгэн бий болгож, Монгол үндэстний үеийн үед мөнхөд ориш эх үндсийг тавьж өгсөн юм. Тэрээр энх тайвныг тогтоож, эртний торгоны замын аюулгүй байдлыг хангаж, худалдаа наймаа, оюуны болон урлаг соёлын солилцоог хөгжүүлэх бололцоог олгосон юм.

Түүхчдийн хүлээн зөвшөөрснөөр Чингис хааны үлдээсэн нэгэн чухал өв болох Монголын их амар амгалан, Европ, Азийг холбосон харилцааг олон зууны туршид хөгжин цэцэглэх боломжийг бүрдүүлсэн юм.

Чингис хаан өнөө үед домогт баатар болж, түүний сүр хүч, дурсамж үеийн үед айх бишрэхийг хослуулан мөнхөрсөөр байна хэмээн үнэлэн дүгнэжээ.

2005 онд Их Монгол Улс байгуулагдсаны түүхт 800 жилийн ойг тохиолдуулан Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблей, Монголчуудын хүн төрөлхтний түүхэнд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлэн олон улсад тэмдэглэн өнгөрөхийг гишүүн орнууддаа уриалсан тогтоол гаргасныг бас та бүхэн мэдэж байгаа. Энэхүү тогтоолд Их Монгол Улс Ази, Европын олон нийгэмд өөрийн улбааг үлдээхийн зэрэгцээ өрнө, дорнын соёл уламжлалыг өөртөө шингээн хүмүүний үнэт зүйлсийн солбицол, дэлхийн иргэншилүүдийг холбосон гүүр нь болж худалдаа арилжааны өргөн сүлжээг хөгжүүлэх, засаг захиргаа, соёл, шашин болон худалдааны томоохон төвүүдийг бий болгож, бүх хэлбэрийн соёл иргэншил хоорондын яриа хэлэлцээ, харилцааг хөгжүүлэхэд гүйцэтгэсэн чухал үүргийг хүлээн зөвшөөрч, Монголчуудын соёл

иргэншилд уламжлагдан ирсэн байгаль дэлхийтэйгээ зохицон амьдрах ёсны ач холбогдол өнөөгийн дэлхий ертөнцөд улам бүр өсөн нэмэгдэж буйг онцлон тэмдэглэж байна хэмээн цохон тэмдэглэсэн байдаг юм.

Энэ бүхнээс үзвэл Чингис хаан болон түүнийг залгамжилсан их хаад дэлхий нийтэд эв эеийг эрхэмлэн, хууль цаазын дор амар амгаланг цогцлоож, шашин шүтлэг, тэгш байдлыг тэтгэсэн ардчилсан үзэл санааг дэлгэрүүлж, худалдаа арилжаа, харилцаа холбоо, соёл иргэншил, шинжлэх ухаан зэрэг олон салбарыг хөгжүүлж, илт солилцох ёс, дипломат албаны ойлголтыг анх бий болгож, өнөөгийн дэлхий ертөнцийн үнэт зүйл, үзэл санаа, даяарилын үндэс суурийг тавьсан хэмээн дэлхий нийтээрээ үнэлж байгаа нь дээрх алдартай хүмүүсийн хэлсэн үг, хийсэн судалгаа, бичсэн ном зохиолоос тод харагдаж байгаа юм.

Их эзэн Чингис хаан эцэг өвгөдийнхөө үүх түүх, өв сургаалыг зүрх сэтгэлдээ хадгалж, үйл хэрэгтээ мөрдлөг болгон төр улсаа удирдсан бөгөөд ард түмэндээ бэлэг сургаалаа сурган айлдаж, хойч үедээ өвлүүлэн үлдээсэн алсын хараатай, холч ухаантай хаан эцэг байсан. 18 дугаар зууны Английн нэрт зохиолч, орчуулагч Пенелопе Оубин Чингис хааны тухай номыг орчуулж, Уэлсийн хунтайжид өргөн барихдаа түүний талаар ариун явдалт, чигч шударга, төлөв төвшин тэргүүн хаан болбоос бас гайхамшигт хань, сайн эцэг, үнэнч анд, ээлт эзэн, ухаалаг жанжин байсан ажгуу хэмээн айлдсан байна.

Тэрбээр ард иргэдээ үр хүүхдээсээ өөрцгүй үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүү

*мэт хүндэлж, өвгөд, өтгөс нялхас, өнчин ядуусыг өргөн тэтгэж, өглөг соёлоо үл хождуулан энэрэл хишгээ түгээдэг, ард олон, ахуй төр, эх хүнийг бүхнээс илүүд үздэг, төрт ёс, шударга үнэнийг эрхэмлэн дээдэлдэг их хүмүүн эзэн хаан байсан.*

*Харин өглөө хэлснээ үдэш нь, үдэш хэлснээ өглөө нь няцаагч, туйлбаргүй зантан, бусдыг бүү хэл өөрийгөө захирч эс чадах ичгүүргүй явдалтан, эд хөрөнгө, эрх мэдэлд ташааравч, шунаг, зальхай, харгис, ёс журамгүй хэнд боловч төрийн хэргийг бүү даатга хэмээн эзэн хаан сурган захисан байдаг. Энэхүү сургаал эдүгээ ч Монгол төрийн албаны үндсэн зарчим, үйл хэрэг болсоор байх ёстой.*

*Эзэн хаанаараа овоггосон эрхэм хүндэт ард иргэд ээ, түүхийн ороо бусгаа аль ч цаг үед Монголын төлөө цохилох зүрхийг нэгтгэж чадах Монгол бахархлыг Их эзэн хаан өөрийн сүр хүч, суу алдраараа Монголчууд бидэнд бүтээж өгсөн юм.*

*Хаан эзний Монголын түүхэнд оруулсан бахдам гавьяа, бахархам үйлсийг юугаар ч үнэлж баршгүй, юутай ч зүйрлэх аргагүй бөгөөд үеийн үед Монголын ард түмний оюун санааны дархлааг бэхжүүлэн, Монгол үндэстнийг нэгтгэн зангидаж байдаг үнэт зүйл билээ.*

*Монголчууд бид эзэн Чингис хааныхаа төрсөн нутаг дэлхийн Монголчуудын гал голомтыг сахин суугаа хариуцлагатай бөгөөд хүндтэй үүргээ ямагт ухамсарлан эзэн хааныхаа их өвийг хайрлан хамгаалж, сурталчлан судалж, түгээн дэлгэрүүлэхэд хэн бүхнээс илүү сэтгэл зүрх, хичээл зүтгэл гаргах ёстой бөгөөд үеийн үед санаж, үйл хэргээрээ*

*харуулж, үе хойчдоо захиж үлдээх ёстой юм.*

*Тиймээс Монгол төрийн тэргүүн зарлиг буулгаж, Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахин буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн богд Чингис хааны иш хэргийг Монгол айл өрх, албан байгууллага бүр хүндэтгэн залж, Эзэн богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билэг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг ард түмнээсээ уриалсан.*

*Чингис хаан нэгэн хүмүүний амьдралд хийж үл барам мянга мянган удирдагчдын хийж бүтээснээс илүү их түүхийг бүтээж, эгнэшигүй суу алдраа дэлхий ертөнцөд дуусгаж, судлан шинжилж үл дуусах ариун их өвийг хүн төрөлхтөнд үлдээсэн байна.*

*Их эзэн Чингис хааны суу алдар, үйл хэргийг гадаад, дотоодод сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, сурвалжлан судлах чиглэлээр төр засаг болон манай үе үеийн төрийн тэргүүн, Ерөнхийлөгч нар, эрдэмтэн мэргэд, ард иргэд, холбогдох байгууллагууд хүчин чармайлт гарган бодит ажлуудыг хийж бүтээж ирснийг энэхүү баярын өдөр тэмдэглэн хэлэхэд сайхан байна.*

*Эрхэм хүндэт Ерөнхийлөгч нартаа бас баярын мэнд хүргэе.*

*Энэ жил Монголчууд бид Их хааныхаа мэндэлсний 860 жилийн ойг тохиолдуулан Их эзэн Чингис хаан, түүний өвөг дээдэс болоод залгамжлагчдын түүхийг харуулсан Чингис хаан хаад язгууртны музейг*

цар тахлын хүнд бэрх цаг үед байгуулан ашиглалтад оруулж чадлаа.

Мөн энэ жил Чингис хааны ертөнц ба Монгол судлал сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, Чингис хаан судлалын олон улсын холбоог байгууллаа. Энэхүү Олон улсын холбоо Чингис хаан музейн их хааны хүн төрөлхтний хөгжилд оруулсан хувь нэмэр, түүний төрт ёс, түүх соёлын өвийг шинжлэн шинжлэх ухаанчаар судлах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, Чингис хаан судлалын хамрах хүрээг өргөтгөх, дэлхийн олон орны эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, идэвхжүүлэх, хамтарсан томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх болно.

Бид цаашидаа үүн дээр ихээхэн анхаарах болно.

Монгол Улс Чингис хаан судлалаар дэлхийд манлайлах учиртай улс аа. Их хааныг хөрстөд мэндэлсэн цагаас хойших бүхий л үйл хэргийг нь дэлхийн агуу хүмүүс, алдарт суутнууд, билиг оюунтнууд, бичгийн мэргэд танин мэдэж, сурвалжлан судлах гэж хэдэн зууныг туулж ирлээ. Тиймээс Чингис хаан болон Монгол судлал, Монголын эзэнт гүрэн судлалаар олон улсын түвшинд ажиллах мэргэжлийн нарийн мэргэжлийн судлаач, эрдэмтдийг төрийн бодлогоор бэлтгэх явдал шаардлагатай байна. Чингис хаан судлал хөгжихийн хэрээр олон орны эрдэмтэн мэргэд, их хааны хүн төрөлхтний хөгжил дэвшилд дэлхийн түүхэнд оруулсан үлэмж их гавьяа зүтгэлийг танин мэдэж, үнэлэн цэгнэж, хүлээн зөвшөөрч, эзэн хаан болон Монголчуудын талаарх үнэн

бодит түүх дэлхий ертөнцөд түгэн дэлгэрэх болно.

Бид хүчирхэг хөгжингүй улс орон байгуулахыг хэдий чинээ эрмэлзэнэ, төдий чинээ эе эвээ хичээж, их түүх, эцэг өвгөдийнхөө мэдлэг ухаан, бэлэг сургаалаас суралцаж, эрт, эдүгээ, ирээдүй 3 цагийн алтан хэлхээг бэхжүүлэх учиртай. Та бидний тусгаар тогтносон улс гэр, эрх чөлөө, өргөн уудам нутаг, хүн ард бахархал, түүх соёл бол эзэн хааны алдар гавьяатай салиггүй холбоотой гэдгийг үеийн үед санаж, эзэн хааныхаа билэг сургаалыг дагаж мөрдөх ёстой.

Эзэн хаан “өндөр уулыг зорь, өргөн далайд гар, хол хэмээн бүү цөхөр, явбаас бүтнэ, их хэмээн бүү шантар, оролдвоос гатална, хүнд хэмээн бүү зүрхшээ, өргөвөөс даана” гэсэн бэлэг сургаалаа чанд баримтлан, агуу түүхийг бүтээж, Их Монгол Улсыг байгуулан дэлхий нийтийг төвиштгөсөн.

Тэгвэл өнөөдөр Монголчууд бид эзэн хааныхаа энэхүү билэг сургаалыг эрхэмлэн дээдэлж, чандлан мөрдөж, төр улс, түмэн олноороо улс Монголынхоо төлөө хичээн зүтгэж, хувь заяандаа эзэн болох аваас их үйлсийг бүтээж, хүчирхэг Монгол Улсыг цогцлоон хөгжүүлж чадна.

Монгол хүн бүр Эзэн Чингис хаанаа хүндэтгэн дээдэлж, бишрэн шүтэж, эрх чөлөө, тусгаар тогтнол, эв нэгдлээ зүрхний тольт нүдний цөцгий мэт хайрлан хамгаалж, эцэг өвгөдийнхөө байгуулсан Их Монгол Улсын үргэлжлэл болохоо өглөө бүр санаж, өдөр бүр хичээж, үдэш бүр цэнэж явахыг түүхэн энэ өдөр эрхэм хүндэт ард иргэддээ уриалж байна.

*Дэлхийн мянганы суут хүмүүн  
өнөөгийн дэлхий ертөнцийг  
үндэслэгчдийн нэг Хаадын хаан, Их  
эзэн Чингис хааны мэндэлсний түүхт  
ойн баярын мэндийг их хааны үр сад  
болсон Монголын ард түмний нэрийн  
өмнөөс дэлхий нийтэд өргөн  
дэвшүүлье.*

*Мөнх тэнгэрийн хүчин дор  
Монгол Улс мандан бадрах болтугай.*

*Баярлалаа, та бүхэндээ,  
баярлалаа.*

**Г.Занданшатар:** *Үг хэлсэн  
Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн  
Хүрэлсүх Танд талархал илэрхийлье.*

*Монголын их амар амгалан мөнх  
оришг ээ.*

*Дэлхий энх тайван, амар  
амгалан байх болтугай.*

*Их эзэн Чингис хаан мэндэлсний  
860 жилийн ой, “Монгол бахархлын  
өдөр”-т зориулсан Улсын Их Хурлын  
хүндэтгэлийн хуралдаан өндөрлөснийг  
мэдэгдье.*

*Одоо 13 цагаас Их эзэн Чингис  
хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга  
хэмжээ болно.*

*Улсын Их Хурлын эрхэм  
гишүүдийг өргөнөөр оролцохыг урья.*

*12.40 цаг*

*Дууны бичлэгээс буулгасан:*  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ**  
**ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**